

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2025/201/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Энхдалай

Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn

Аудитор: Я.Марал-Эрдэнэ

Утас: 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ниямазон аудит ХХК-ийн  
захирал З.Цээнээ

Цахим хаяг: audit@nmz.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/753  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс төрийн албан хаагчдын үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал 30 орчим хувиар өссөн байна.

Тайлант онд Шинэ эрин сургууль нь Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Нийслэлийн боловсролын газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 87,273.4 мянган төгрөгийн техник хэрэгсэл, Боловсролын ерөнхий газраас 2,486.3 мянган төгрөгийн техник хэрэгслийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

### Аудитын гол асуудал

Тус сургууль нь Кембрижийн олон улсын хөтөлбөр болон үндэсний хөтөлбөрийн хичээл, сургалт, олон улсын шалгалтанд ашиглагдах хими, биологийн бодис, урвалж туршилтын багаж хэрэгсэл, материалуудыг хичээлийн үндсэн хэрэглэгдэхүүн болгон ашигладаг.

Тухайн хичээлийн жилд Кембрижийн олон улсын Gheckpoint IGCSE, ASIA түвшний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид цахимаар олон улсын шалгалтаа өгөх эрхээ авч төсөл амжилттай хэрэгжиж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Монгол улсад анх удаа Кембрижийн хөтөлбөр хэрэгжүүлдэг сургуулиудын шилдэг сурагчдад шагнал гардуулах "Outstanding cambridge learner awards mongolia" үйл ажиллагаанд 2024 оны хаврын шалгалтын дүнгээр тус сургуулийн 3 сурагч шалгарсан байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 3 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	59,098,816.74	62,263,585.67
33	АВЛАГА	68,780.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	68,780.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	59,030,036.74	62,263,585.67
351	Түүхий эд материал	37,683,123.74	37,459,499.67
35110	Тусгай зориулалттай материал	37,683,123.74	37,459,499.67
354	Хангамжийн материал	21,346,913.00	24,804,086.00
35410	Бичиг хэргийн материал	3,966,600.00	3,780,000.00
35420	Аж ахуйн материал	14,164,591.00	18,545,364.00
35440	Түлш, шатах тослох материал	191,300.00	500,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,024,422.00	1,978,722.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,817,303,709.12	3,753,337,061.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,817,303,709.12	3,753,337,061.51
392	Биет хөрөнгө	3,801,494,625.75	3,743,214,294.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,750,560,295.00	3,750,560,295.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(334,871,455.20)	(401,845,746.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,000,000.00)	(277,777.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	294,587,060.83	417,814,805.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	(104,502,445.39)	(178,657,657.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	304,312,041.26	307,472,041.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	(123,633,039.21)	(176,879,226.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,744,680.00	4,893,680.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(818,045.04)	(981,653.04)
39217	Ном	11,115,533.50	11,115,533.50
393	Биет бус хөрөнгө	15,809,083.37	10,122,766.73
39301	Программ хангамж	31,345,900.00	31,345,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(15,536,816.63)	(21,223,133.27)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,876,402,525.86	3,815,600,647.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,876,402,525.86	3,815,600,647.18
51	Засгийн газрын хувь оролцоо	3,876,402,525.86	3,815,600,647.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,132,187,517.32	3,132,187,517.32
51101	Өмч: - төрийн	3,132,187,517.32	3,132,187,517.32
512	Хуримтлагдсан үр дүн	(1,140,184,800.95)	(1,200,986,679.63)
51210	Өмнөх үеийн үр дүн	(933,557,468.66)	(1,140,184,800.95)
51220	Тайлант үеийн үр дүн	(206,627,332.29)	(60,801,878.68)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,884,399,809.49	1,884,399,809.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,876,402,525.86	3,815,600,647.18

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,860,354,174.00	2,759,829,077.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,891,274.00	116,538,707.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,891,274.00	116,468,747.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,241,874.00	116,468,747.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,241,874.00	15,000,002.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	101,468,745.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал	1,649,400.00	69,960.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,835,462,900.00	2,643,290,370.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,835,462,900.00	2,628,831,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,835,462,900.00	2,628,831,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	14,458,670.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	14,458,670.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,002,783,609.98	2,820,630,955.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,002,783,609.98	2,820,630,955.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,987,676,459.99	2,786,734,489.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,359,154,350.84	1,805,891,819.88
210101	Үндсэн цалин	637,442,040.00	1,002,370,787.96
210102	Нэмэгдэл	546,598,430.55	559,175,071.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,040,500.00	114,915,600.00
210104	Урамшуулал	120,073,380.29	129,430,360.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	170,392,178.15	224,158,425.44
210201	Тэтгэврийн даатгал	116,976,431.63	155,044,490.84
210202	Тэтгэмжийн даатгал	13,731,521.29	18,165,993.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,870,817.08	9,027,636.52
210204	Ажилгүйдлийн даатгал	2,619,400.68	8,356,744.10
210205	Эрүүл мэндийн даатгал	26,194,007.47	33,563,560.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,813,145.34	63,765,000.00
210301	Гэрэл, цахилгаан	32,037,861.01	33,790,706.66
210302	Түлш, халаалт	19,546,552.21	15,977,686.59
210303	Цэвэр, бохир ус	14,228,732.12	13,996,606.75
2104	Хангамж, бараа материалын зардал	42,725,393.98	46,231,455.57
210401	Бичиг хэрэг	6,161,250.00	8,047,099.00
210402	Тээвэр, шатахуун	7,289,188.40	3,871,390.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,270,947.58	16,972,528.27
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,004,008.00	11,411,298.30
210408	Бараа материал акталсны зардал	-	5,929,140.00
2105	Нормативт зардал	245,850.00	515,390.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	515,390.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,286,168.30	296,274,010.26
210604	Урсгал засвар	18,286,168.30	296,274,010.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	104,699,555.67	104,008,501.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,554,865.67	84,082,906.55
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	5,000,000.00

**Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	121,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,979,790.00	14,771,095.31
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	226,359,817.71	245,889,886.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,740,100.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,433,360.40	45,386,494.11
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	198,186,357.31	200,503,392.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,107,149.99	33,896,465.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	640,000.00	32,040,193.25
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	27,210,193.25
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	640,000.00	4,830,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,467,149.99	1,856,272.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,467,149.99	1,810,802.70
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	45,470.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(142,429,435.98)	(60,801,878.68)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	64,197,896.31	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	64,197,896.31	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(64,197,896.31)	-
5	НИЙТ ҮР ДҮН	(206,627,332.29)	(60,801,878.68)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,858,704,774.00	2,658,290,372.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,241,874.00	15,000,002.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,241,874.00	15,000,002.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,241,874.00	15,000,002.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,241,874.00	15,000,002.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,835,462,900.00	2,643,290,370.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,835,462,900.00	2,628,831,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,835,462,900.00	2,628,831,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	14,458,670.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	14,458,670.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,810,837,484.00	2,623,222,372.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,810,837,484.00	2,623,222,372.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,795,730,334.01	2,589,325,906.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,360,272,930.58	1,805,971,222.88
210101	Үндсэн цалин	591,187,988.71	955,443,608.87
210102	Нэмэгдэл	578,699,396.86	602,840,215.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,915,257.59	114,668,452.40
210104	Урамшуулал	135,470,287.42	133,018,946.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	170,304,208.14	224,089,645.44
210201	Тэтгэврийн даатгал	116,896,513.14	151,531,121.67
210202	Тэтгэмжийн даатгал	13,607,633.34	18,638,260.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,815,846.75	9,315,930.04
210204	Ажилгүйдлийн даатгал	2,634,874.02	9,254,606.73
210205	Эрүүл мэндийн даатгал	26,349,340.89	35,349,726.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,813,145.34	63,765,000.00
210301	Гэрэл, цахилгаан	32,037,861.01	33,790,706.66
210302	Түлш, халаалт	25,447,577.10	15,977,686.59
210303	Цэвэр, бохир ус	8,327,707.23	13,996,606.75
2104	Хангамж, бараа материалын зардал	38,932,615.58	33,485,023.57
210401	Бичиг хэрэг	3,791,600.00	1,011,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,348,300.00	4,110,130.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,270,947.58	16,972,528.27
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,521,768.00	11,391,365.30
2105	Нормативт зардал	276,700.00	293,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	276,700.00	293,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,232,233.30	305,332,536.26
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,235,700.00	2,251,150.00
210604	Урсгал засвар	19,996,533.30	303,081,386.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	104,660,955.67	103,929,098.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,516,265.67	84,003,503.55
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	121,500.00

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,979,790.00	14,771,095.31
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,237,545.40	52,460,379.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,740,100.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,497,445.40	52,460,379.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,107,149.99	33,896,465.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	640,000.00	32,040,193.25
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	27,210,193.25
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	640,000.00	4,830,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,467,149.99	1,856,272.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,467,149.99	1,810,802.70
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	45,470.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	47,867,290.00	35,068,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	47,867,290.00	35,068,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,867,290.00	35,068,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	47,867,290.00	35,068,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	47,867,290.00	35,068,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(47,867,290.00)	(35,068,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,132,187,517.32	1,884,399,809.49	(933,557,468.66)	4,083,029,858.15
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,132,187,517.32	1,884,399,809.49	(933,557,468.66)	4,083,029,858.15
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(206,627,332.29)	(206,627,332.29)
8	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,132,187,517.32	1,884,399,809.49	(1,140,184,800.95)	3,876,402,525.86
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,132,187,517.32	1,884,399,809.49	(1,140,184,800.95)	3,876,402,525.86
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(60,801,878.68)	(60,801,878.68)
20	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,132,187,517.32	1,884,399,809.49	(1,200,986,679.63)	3,815,600,647.18

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,643,831,700.00	2,642,020,899.30	1,810,800.70	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,643,831,700.00	2,642,020,899.30	1,810,800.70	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,615,726,100.00	2,614,180,706.05	1,545,393.95	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,806,368,300.00	1,805,971,222.88	397,077.12	100.0
210101	Үндсэн цалин	978,881,500.00	955,443,608.87	23,437,891.13	97.6
210102	Нэмэгдэл	603,217,900.00	602,840,215.21	377,684.79	99.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	130,398,400.00	114,668,452.40	15,729,947.60	87.9
210104	Урамшуулал	93,870,500.00	133,018,946.40	(39,148,446.40)	141.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	225,130,500.00	224,089,645.44	1,040,854.56	99.5
210201	Тэтгэврийн даатгал	156,194,600.00	151,531,121.67	4,663,478.33	97.0
210202	Тэтгэмжийн даатгал	17,234,000.00	18,638,260.08	(1,404,260.08)	108.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,617,000.00	9,315,930.04	(698,930.04)	108.1
210204	Ажилгүйдлийн даатгал	8,617,000.00	9,254,606.73	(637,606.73)	107.4
210205	Эрүүл мэндийн даатгал	34,467,900.00	35,349,726.92	(881,826.92)	102.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,765,000.00	63,765,000.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	27,430,000.00	33,790,706.66	(6,360,706.66)	123.2
210302	Түлш, халаалт	21,525,000.00	15,977,686.59	5,547,313.41	74.2
210303	Цэвэр, бохир ус	14,810,000.00	13,996,606.75	813,393.25	94.5
2104	Хангамж, бараа материалын зардал	33,485,900.00	33,485,023.57	876.43	100.0
210401	Бичиг хэрэг	1,030,500.00	1,011,000.00	19,500.00	98.1
210402	Тээвэр, шатахуун	8,829,000.00	4,110,130.00	4,718,870.00	46.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,715,000.00	16,972,528.27	(2,257,528.27)	115.3
210404	Ном, хэвлэл	82,400.00	-	82,400.00	00.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,829,000.00	11,391,365.30	(2,562,365.30)	129.0
2105	Нормативт зардал	293,000.00	293,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	293,000.00	293,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	337,710,000.00	337,700,536.26	9,463.74	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	34,620,000.00	34,619,150.00	850.00	100.0
210604	Урсгал засвар	303,090,000.00	303,081,386.26	8,613.74	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,505,400.00	96,415,898.86	89,501.14	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	79,577,300.00	79,528,303.55	48,996.45	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,962,000.00	1,962,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	129,400.00	121,500.00	7,900.00	93.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	64,700.00	33,000.00	31,700.00	51.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,772,000.00	14,771,095.31	904.69	100.0

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,468,000.00	52,460,379.04	7,620.96	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	52,468,000.00	52,460,379.04	7,620.96	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,105,600.00	27,840,193.25	265,406.75	99.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,105,600.00	27,840,193.25	265,406.75	99.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,474,800.00	27,210,193.25	264,606.75	99.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	630,800.00	630,000.00	800.00	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,643,831,700.00	2,642,020,899.30	1,810,800.70	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,628,831,700.00	2,627,020,897.30	1,810,802.70	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,628,831,700.00	2,627,020,897.30	1,810,802.70	99.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,000,000.00	15,000,002.00	(2.00)	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	15,000,002.00	(2.00)	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	444	444	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	53	53	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	43	43	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	9	9	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	390	390	-	100.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	390	390	-	100.0
630001	Төрийн өмчит ЕБС	390	390	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	14,458,670.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	14,458,670.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	10,213,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,700,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	7,513,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,475,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	3,038,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	4,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	4,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,200,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	45,470.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлэх шилжүүлэг	-	45,470.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	14,458,670.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	14,458,670.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	14,458,670.00

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 21,815.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1.	21,815.0 мянган төгрөгийн элсэлтийн шалгалтын хураамжийн орлогод и-баримт шивээгүй байна.	1	21,815.0					1	21,815.0						
Дүн		1	21,815.0					1	21,815.0						